

ТАВИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдсан газар огноо: Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Тоо вангийн гудамж, UB City зочид буудлын хурлын танхимд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 11:10 цагт хурлыг эхлүүлэхээр хурлын дарга үг хэлж эхлэв.

Хурлын дарга Ц.Байгалмаа /цаашид "Хурлын дарга" гэх/: Өглөөний мэнд хүргэе. Тооллогын комиссын даргаа, 11:10 минут боллоо. Ирц ямар байна вэ.

Тооллогын комиссын дарга Д.Нарантунгалаг: Дөнгөж сая хувьцаа эзэмшигч Э.Батхүү, С.Цолмон нар ирснээр ирц бүрдлээ. Хурлаа албан ёсоор эхлэх боломжтой... (гээд албан ёсны ирцийг танилцуулах гэтэл үгийг таслаад)

Хувьцаа эзэмшигч Э.Батхүү: Энэ хурал юун хурал вэ. Хурал хуралдуулдаг чи хэн бэ. Гүйцэтгэх удирдлага нь хуралдуулах ёстой биз дээ. Тэр хүнийг би идэж уусан хэргээр нь цагдаад өгсөн байгаа. Та нарыг ч гэсэн цагдаад өгнө. Тэр ахыг чинь яаж хувьцаа авсныг мэдэхгүй хүн байгаа бол би одоо ярьж өгье. Наад хурлыг чинь эхлүүлэхгүй. Хурлыг ингэж хийдэггүй юм. Би одоо гаднаас өөр хувьцаа эзэмшигчдийг дуудна... (гэх зэргээр дайрч давшлав.)

Хурлын дарга: Батхүү гуай, энэ удаагийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигч нарын санаачлагаар хуралдуулж байгаа. Санаачилсан хувьцаа эзэмшигчийн нэг болох миний бие хурал даргалахаар материалаа бүрдүүлж өгөөд хурлаа зохион байгуулж байна.

Хувьцаа эзэмшигч Банзрагч: Та нарын хуралдуулсан ээлжит бус хурал чинь хүчингүй гээд дээд шүүх дээр маргаан чинь шийдвэрлэгдчихээд байгаа. Та нарын олон жилийн болчимгүй үйлдлээс болоод энэ компаний үйл ажиллагаа маш их доголдож санхүүгийн хувьд ч хүнд байна. Харин та хоёр хувьчлал болох үеэр үйлдвэрийн удирдлага байсны хувьд ажилчдынхаа хувьцааг яаж авсан яаж бүртгүүлсэн болон газар бусад өмч хөрөнгийг яаж үрэн таран хийсэн гээд яривал ч их юм бий шүү. Заримаас нь хоёулаа өөрийн чинь нэхэмжлэхтэй шүүх дээр яриад явж байгаа байхаа. Больж үз. Хувьцаа эзэмшигчид эрхийнхээ хүрээнд ээлжит бус хурлаа хуралдуулах гэж байна. Битгий санаатай самраад бай

Хувьцаа эзэмшигч Батхүү: Би та нартай үхэн үхтлээ тэмцэнэ. Бүгдийг чинь олигтой явахыг харна.

Хувьцаа эзэмшигч Банзрагч: Та дандаа ингэж байхаа больж үз. Ядаж хурлын дараа ярьж болноодоо. Одоо биднийг барьж авч зодох нь шив дээ. Таны худлаа ярьж эрх бүхий байгууллагаар явдаг үйлдлээс чинь бид битгий хэл шүүх цагдаа эрх бүхий байгууллагууд нь залхаж ажлаа хийхэд нь саад учирч, манай компаний бусад 70%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн өмч үнэгүйдэж өр төлбөртөө баригдаж байна.

Хувьцаа эзэмшигч Батхүү: Та нар шиг муусайн хулгайчуудыг зодсон ч яадаг юм бээ. Та нарыг бүгдийг чинь цагдаад өгнө. Өдөр болгон цагдаагийн үүдэнд суулгана. Би өчигдөр үйлдвэр дээр очисон түрээслэгчийг чинь хөөсөн. Та нарыг ингэж давраахгүй. Одоо би бусад хүмүүсээ дуудсан байгаа. Тэд нарыг ирэхээр та нар наад хурлаа хуралдуулахыг чинь харна.

Хувьцаа эзэмшигч Баярмаа: Та яахаараа дандаа ингэж байдаг юм бэ. Та хоёр өчнөөн жил компаний үйл ажиллагаанд саад болж өмнөх томоохон түрээслэгч нарыг үргээсэнээс болоод компани орлогогүй болж өр зээлэндээ баригдаад хэцүү байгаа шүү. Таны удаа дараагийн бусармаг үйлдлээс үүдсэн компаний хохирлыг нэхэмжилж зохих байгууллагад нь адилхан хувьцаа эзэмшигчийн хувиар гомдол гаргана шүү. Одоо энэ хурлаар ТУЗ-ээ байгуулаад гүйцэтгэх удирдлагаа сайн ажиллуулахаар хичээж байхад та бусад хувьцаа эзэмшигч рүү дайрч, түрээслэгч нарыг очиж хөөж дарамтлахаа болиочээ.

Хувьцаа эзэмшигч Ч.Баясгалант: Одоо наад хэрүүлээ зогсоогоод саналаа өгье.

(гэх мэтээр маргалдаан 11 цаг 50 минут хүртэл үргэлжлэв.)

Хурлын дарга: За одоо маргаанаа зогсоож хурлаа эхэлье. Энэ заалын түрээслэж буй хугацаа яваад байна. Тооллогын комиссын дарга ирцийг албан ёсоор танилцуулаарай.

Тооллогын комиссын дарга Д.Нарантунгалаг: Тавилга ХК нь нийт 122.754 ширхэг хувьцаатай байх ба өнөөдрийн ээлжит бус хуралд 112987 ширхэг хувьцааг эзэмшигчид хүрэлцэж ирсэн нь нийт хувьцааны 92.04% болж байх тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заагдсаны дагуу хурлын ирц бүрдсэн байна. Хуралд ТУЗ-д нэр дэвшигчид ирсэн байна.

11 цаг 55 минутад хурлын дарга хурлыг албан ёсоор нээж үг хэлэв: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Компанийн тухай 61 дүгээр зүйлийн 61.7-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг саналын эрхийн 10-с дээш хувийн хувьцаа эзэмшигч зарлах тухай шийдвэр гаргах эрхзүйн зохицуулалттай байх тул Тавилга ХК-ийн хувьцааны 12.13%-ийг эзэмшигч Ц.Баярмаа, 10.28%-ийн хувьцааг эзэмшигч Ч.Баясгалант, 8.96%-ийн хувьцааг эзэмшигч миний бие Ц.Байгалмаа нар хамтран хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахаар зарлаж та бүхэн хүрэлцэн ирээд байна. Ээлжит бус хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэж ажилласан ба Тооллогын комиссын даргын мэдэгдснээр хурлын ирц бүрдсэн байгаа тул хурлаа эхлүүлэе. Өнөөдрийн хурлаар "Тавилга" ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох нэг асуудлыг хэлэлцүүлнэ. Ингээд хурлын дэгийг танилцуулая. (хурлын дэг танилцуулав.)

Хурлын дарга: Түрүүн хэлсэнчлэн өнөөдрийн хурлаар компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэнэ. Манай компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулъя. (Хурлын танилцуулга материал дахь ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулав.)

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудалтай холбоотой асууж тодруулах зүйл байгаа талаар тодруулъя.

Хувьцаа эзэмшигч С.Цолмон: Хурлын материалын таницуулгыг авъя. ТУЗ-ийг томилох юмуу. Хурлын зараа яаж хүргэсэн бэ.

Хурлын дарга: Хурлын зарыг журмын дагуу хоёр удаа өдөр тутмын сонин болон телевизэрээр хүргэж, хурлын материалыг брокер, дилерийн компаниудад тараасан байгаа. Мөн хөрөнгийн биржийн цахим сайтад хурлын мэдээлэл цаг хугацаандаа нийтлэгдсэн байгаа. Энэ удаагийн ээлжит бус хурлаар зөвхөн ТУЗ сонгоноо.

Хувьцаа эзэмшигч С.Цолмон: Бид АНУ-д байгаа Мөнхбилэгийг ТУЗ-д нэр дэвшүүлэх байсан юм эртхэн мэдсэн бол. Одоо бид саналын хуудсан дээр нэрийг нь бичээд саналаа өгье.

Хурлын дарга: Одоо нэр дэвшүүлэх боломжгүй, саналын хуудсан дээр нэр дэвшигчдэд хүмүүст саналаа өгнө. Цолмон гуай, Батхүү гуай та хоёр нэр дэвшигчдийн дунд байгаа шүү.

Хувьцаа эзэмшигч Батхүү: Яахаараа одоо нэр дэвшүүлж болдоггүй юм. Би өөрийнхөө хүмүүсийг дуудсан байгаа одоо ирэхээр нь яаж хурлаа хийхийг чинь харнаа.

Хувьцаа эзэмшигч С.Цолмон: ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчид ямар хүмүүс байгаа вэ.

Хурлын дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг анкет хурлын материал дотор байгаа та танилцаарай.

(Өөр асууж тодруулах зүйл байхгүй байсан тул санал хураалтыг кумулятив аргаар хураав.)

(Хурал түр завсарлаад үргэлжлэв.)

Хурлын дарга: Тооллогын комиссын дүнг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд Ц.Банзрагч, Ц.Баярмаа, Ц.Бат-Амгалан, Ч.Баясгалант, Ц.Байгалмаа, Ц.Баянмөнх нар сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Б.Өлзийбаяр, Ч.Амгалантуяа, Д.Цэцэгмаа нар сонгогдлоо.

Хурлын дарга: тус хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлын дарга хурлыг хаав.

Дарга: Ц.Байгалмаа

